# АГУУЛГА

**ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 3**

**БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 4**

1.1. Төслийн байршил ..... 4
1.2. Орчны төлөв байдал ..... 5
1.3. Ордын геологийн нөөц ..... 6
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц ..... 6
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим ..... 7
1.5.1. Уурхайн хүчин чадал ..... 7
1.5.2. Уурхайн ажиллах горим ..... 7
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал ..... 7

**БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД ..... 8**

2.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал ..... 8
2.2. Хөрсний чанарт нөлөөлөх байдал ..... 8
2.3. Усны чанарт нөлөөлөх байдал ..... 8
2.4. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал ..... 9
2.5. Амьтны аймагт нөлөөлөх байдал ..... 9
2.6. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс ..... 9
2.7. Төслийн болзошгүй нөлөөллүүд ..... 10

**БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН ..... 11**

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 11
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ..... 13
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 16
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 17
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 18
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 18
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 20
3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ..... 23
3.9. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ ..... 26
3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... 27
3.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ..... 28
3.12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл ..... 29

**ДҮГНЭЛТ ..... 30**

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол .... 4
Хүснэгт 1.2. “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын геологийн нөөц (2017 оны ТЭЗҮ) .... 6
Хүснэгт 1.3. Уурхайн ажиллах горим, хүчин чадал .... 7
Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа .... 10
Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .... 11
Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт .... 16
Хүснэгт 3.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .... 20
Хүснэгт 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .... 21
Хүснэгт 3.5. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ .... 27
Хүснэгт 3.6. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь .... 28
Хүснэгт 3.7. 2023 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүдийн харьцуулалт .... 29

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг .... 4
Зураг 3.1. Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлсэн байдал .... 12
Зураг 3.2. Ахуйн шавьш мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх гэрээ .... 12
Зураг 3.3. Шавьж усmгалын төлбөрийн баримт .... 13
Зураг 3.4. 2023 онд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай .... 13
Зураг 3.5. 2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай .... 14
Зураг 3.6. Нөхөн сэргээлт хийж буй байдал .... 14
Зураг 3.7. Уурхайн дотоод зам талбайг түрж тэгшилсэн байдал .... 14
Зураг 3.8. Нөхөн сэргээлт хийгдэж дууссан байдал .... 15
Зураг 3.9. Үйлдвэрийн талбайн дэргэд мод тарьж буй байдал .... 15
Зураг 3.10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын баримт .... 16
Зураг 3.11. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр мод тарьсан ажлын тайлан .... 17
Зураг 3.12. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд .... 18
Зураг 3.13. Ажилчдыг сургалтанд хамруулж буй байдал .... 19
Зураг 3.14. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээ .... 21
Зураг 3.15. Уурхай, үйлдвэрийн талбай орчмын хог хаягдлыг цэвэрлэж буй байдал .... 21
Зураг 3.16. Бохир ус татан зайлуулах гэрээ .... 22
Зураг 3.17. Хөрсний шинжилгээний үр дүн .... 23
Зураг 3.18. Усны шинжилгээний үр дүн .... 24
Зураг 3.19. Агаар, дуу чимээний хэмжилтийн үр дүн .... 25
Зураг 3.20. Дүүргийн камержуулалтын ажилд оролцсон төлбөрийн баримт .... 26

# ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

| № | ҮЗҮҮЛЭЛТ | УТГА |
|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | “КҮНЛҮН” ХХК |
| 2 | Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл | Улсын бүртгэлийн дугаар: 9019006127<br>Бүртгэсэн огноо: 2005.12.19<br>Регистрийн дугаар: 2745534 |
| 3 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо, Налайх гол-1 |
| 4 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл | Захирал: Liu Yang<br>Утас: 9925-4796 |
| 5 | Төслийн нэр | Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Налайх гол-1” нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах, тоосго үйлдвэрлэх төсөл |
| 6 | Төслийн байршил | Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 3-р хороо |
| 7 | Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар | MV-009192 |
| 8 | Тусгай зөвшөөрлийн хугацаа | Олгосон огноо : 2005.01.24<br>Дуусах огноо: 2035.01.24 |
| 9 | Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ | 4.04 га |
| 10 | Ордын үлдэгдэл геологийн нөөц | 45.37 мян.$м^3$ (2023 оны ТЭЗҮ) |
| 11 | Ордын үйлдвэрлэлийн нөөц | 40.44 мян.$м^3$ (2023 оны ТЭЗҮ) |
| 12 | Шавар олборлолтын жилийн хүчин чадал | 13.5 мян.$м^3$ |
| 13 | Тоосго үйлдвэрлэлийн жилийн хүчин чадал | 4.0 сая ширхэг |

# БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн байршил

“Налайх гол-1” тоосгоны шаврын уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 36 км зайд байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Уг орд байрлаж буй нийт 4.04 га талбай бүхий MV-009192 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол*

| № | Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр | Талбайн хэмжээ, га | Солбилцол | |
|---|---|---|---|---|
| | | | Өргөрөг | Уртраг |
| 1 | MV-009192 Налайх гол-1 | 4.04 | 47° 44' 45.78" | 107° 18' 1.36" |
| 2 | | | 47° 44' 54.78" | 107° 18' 1.36" |
| 3 | | | 47° 44' 54.78" | 107° 17' 54.37" |
| 4 | | | 47° 44' 45.78" | 107° 17' 54.37" |




*Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг*

## 1.2. ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

**Уул зүй:** Уул зүйн хувьд ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт Налайхын хотгорт хамаарагдана. Энэхүү хотгорын туйлын өндөржилт далайн түвшнээс дээш 1400-1420 м (ордын талбайн хэсэгт) байна. Орд байрлаж буй хотгор нь баруунаас зүүн тийш чиглэлтэй, гонзгойдуу хэлбэртэй, төв хэсэгтээ хонхордуу, төв, зүүн талдаа тэгшивтэр талархаг гадаргуу үүсгэсэн байдаг.

**Усан сүлжээ:** Усан сүлжээний хувьд ордын хойгуур Туул гол урсан өнгөрөх ба Туул голын усны зардал маш тогтворгүй, зун борооны үед голын усны түвшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилдэг байна. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м, гүн нь 0.8-3.5 м, мөн уулнаас эх авсан жижиг гол горхиуд Туул голд цутгадаг. Ордын зүүн талаар Налайхын гол урсах ба голын хөндийд жижиг тойрмууд тохиолддог байна.

**Цаг уур:** Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур эрс хэлбэлзэлтэй, атмосферийн тунадасны хэлбэлзэл 120-220 мм бөгөөд жилийн дунджаар 200 мм хүрнэ. Анхны цас 9-р сарын 15-ны үеэр, сүүлчийн цас 5-р сарын 15-ны үеэр орох жишээтэй байдаг. Хамгийн халуун нь 7-р сард, хамгийн хүйтэн нь 1-р сард болдог. Хамгийн их хур тунадас унадаг улирал нь зун байна. Өвөл хөрс нь 3-5 м гүн хөлддөг. Цэвдэгшилт нилээд тархалттай бөгөөд газрын тогтоц, чулуулгийн литологийн бүтцээс хамаарч нам дор газар 1.5-2.0 м, өндөрлөг хэсэгт 3.5-5.0 м-т тохиолдоно. Ордын дүүрэг нь газар хөдлөлтийн VII-VIII бүсэд хамаарна.

**Хүн ам зүй:** Налайх тосгон нь 7 мянга гаруй өрхийн 26 мянга орчим хүн амтай бөгөөд Халх, Казак, Буриад, Урианхай, Дөрвөд зэрэг ястнуудаас бүрдэнэ.

**Дэд бүтэц:** Дэд бүтцийн хувьд орд нь сайн хөгжсөн бүсэд оршдог, Улаанбаатар хоттой асфальтан зам болон төмөр замаар холбогдсоноос гадна өндөр хүчдэлийн шугам, үүрэн телефоны операторууд бүгд холбогдсон, интернет 4G сүлжээтэй холбогдсон байдаг. “Налайх гол-1” тоосгоны шаврын орд орших Налайхын хотгорын хэмжээнд сүүлийн жилүүдэд Хятад, Монголын 10 гаруй тоосгоны үйлдвэр ажиллаж байна. Улаанбаатар хотын төвөөс төслийн талбай руу 1 цагийн хугацаанд авто машинаар хүрэх боломжтой.

**Зам харилцаа:** Налайх дүүрэг нь зам харилцааны хувьд Улаанбаатар хоттой хатуу хучилттай болон төмөр замаар холбогддог. Чиглэлийн автобус, галт тэрэг болон бусад машин техникийн саадгүй үйлчилгээтэй. Тосгоны баруун талаар Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам, хойд талаар Улаанбаатар-Хэнтий чиглэлийн мянганы зам дайрч өнгөрдөг. Зүүн аймгуудын автотээврийн гол зам дайран өнгөрдөг тул зүүн аймгуудтай харилцах зам, харилцааны зангилаа болдог.

## 1.3. Ордын геологийн нөөц

Ордын нөөцийн АМГ-ын даргын 2010 оны 04 сарын 06-ний өдрийн 138 тоот тушаалаар батлагдсан, ЭБМЗ-ийн 2010 оны 02 сарын 27-ний өдрийн №: XX-03-07 тоот дүгнэлт мөн АМГ-ын 2016 оны 08 сарын 01-ний өдрийн Н/91 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2016 оны 07 сарын 05-ний өдрийн №: XX-07-02 тоот дүгнэлт тус тус гарсан.

“Күнлүн” ХХК-нь 2016 онд АМГ-ын УУХ-т 2015 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлэн нөөцийн хасалт хийгдсэн. Мөн 2016 онд нэмэлт хайгуулын ажил хийж доод давхаргын 4 блокийн нөөцийг нөөцийн ЭБМЗ-ийг хурлаар батлуулсан байдаг.

2017 онд ТЭЗҮ-ийг боловсруулахдаа дээд давхаргын нөөцийн үлдэгдэл болон шинээр ЭБМЗ-өөр орсон доод давхаргын нөөцөд тулгуурласан байна.

“Налайх гол-1” тоосгоны шаврын ордын геологийн нөөц нь 2017 оны 4-р сарын 21-ний байдлаар 183.24 мян.м$^3$ байна.

*Хүснэгт 1.2. “Налайх гол-1” тоосгоны шаврын ордын геологийн нөөц (2017 оны ТЭЗҮ)*

| № | Нөөцийн блокийн дугаар ба нөөцийн зэрэг | Блокийн талбай, м$^2$ | Хуулах хөрсний дундаж зузаан, м | Ашигт малтмалын дундаж зузаан, м | Хуулах хөрсний эзэлхүүн, м$^3$ | Ашигт малтмалын нөөц, м$^3$ |
|---|---|---|---|---|---|---|
| **Дээд давхарга** | | | | | | |
| 1 | B-I | 1253.00 | 0.65 | 2.86 | 815.00 | 3584.00 |
| 2 | B-II | 3955.00 | 0.62 | 2.70 | 2452.00 | 10679.00 |
| 3 | B-III | 13090.00 | 0.57 | 2.70 | 7461.00 | 34689.00 |
| **-** | **Нийт** | **18298.00** | **0.59** | **2.68** | **10728.00** | **48951.60** |
| **Доод давхарга** | | | | | | |
| 4 | B-1 | 11568.38 | - | 7.24 | - | 83755.07 |
| 5 | C-1 | 2893.27 | - | 7.80 | - | 22567.51 |
| 6 | C-2 | 2669.81 | - | 6.90 | - | 18421.69 |
| 7 | C-3 | 1316.32 | - | 7.25 | - | 9543.32 |
| **-** | **Нийт** | **18448.00** | **-** | **7.28** | **-** | **134287.59** |
| **Ордын нийт нөөц** | | | | | | |
| 8 | B нөөц | 29866.70 | 0.36 | 4.44 | 10728.00 | 132707.00 |
| 9 | C нөөц | 6879.40 | - | 7.35 | - | 50533.00 |
| **Нийт** | | **36746.00** | **0.29** | **4.99** | **12777.78** | **183239.19** |

## 1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

“Налайх гол-1” тоосгоны шаврын ордыг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 40.44 мян.м$^3$ байхаар ТЭЗҮ-ийн тодотголд тооцож тусгасан байна.

## 1.5. УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

### 1.5.1. УУРХАЙН ХҮЧИН ЧАДАЛ

Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 13.49 мян.$м^3$ тоосгоны шавар олборлон боловсруулахаар тооцож тусгасан байна.

### 1.5.2. УУРХАЙН АЖИЛЛАХ ГОРИМ

"Налайх гол-1" тоосгоны шаврын уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 5-р сарын 1-нээс 10-р сарын 1-нийг хүртэл жилд нийтдээ 5 сар ажиллана.

*Хүснэгт 1.3. Уурхайн ажиллах горим, хүчин чадал*

| № | Горимын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Жилийн хуанлийн хоног | хоног | 365 |
| 2 | Өвлийн улирлын сул зогсолт | хоног | 209 |
| 3 | Жилийн ажиллах хуанлийн хоног | хоног | 156 |
| 4 | Баяр ёслолын амралт | хоног | 7 |
| 5 | Цаг агаарын саатал | хоног | 5 |
| 6 | Засвар үйлчилгээ | хоног | 7 |
| 7 | Олборлолтын ажлын хоног | хоног | 153 |
| 8 | Хоногт ажиллах ээлжийн тоо | ээлж | 1 |
| 9 | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 8 |
| 10 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.8 |
| 11 | Хоногт ажиллах бодит цаг | цаг | 6.4 |
| 12 | Жилд ажиллах бодит цаг | цаг | 1224 |
| 13 | Уурхайн цагийн хүчин чадал | $м^3$/цаг | 13.77 |
| 14 | Уурхайн хоногийн хүчин чадал | $м^3$/хоног | 88.13 |
| 15 | Уурхайн жилийн хүчин чадал | $м^3$/жил | 13485.0 |

## 1.6. УУРХАЙН ТАЛБАЙД АШИГЛАЛТ ЯВУУЛАХ ДАРААЛАЛ

"Налайх гол-1" нэртэй тоосгоны шаврын ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах дарааллын дагуу явагддаг.

***Шавар олборлолт:***

**ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ТООСГОНЫ ШАВАР ОЛБОРЛОЛТ**

***Тоосго үйлдвэрлэл:***

**ТООСГО ҮЙЛДВЭРЛЭХ ► ХАТААХ ► ШАТААХ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.**

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.

# БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

## 2.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон утаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Шавар олборлох уурхайд:

- *Хөрс хуулах, шавар олборлох үед тоос үүсэх,*
- *Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос,*
- *Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий,*
- *Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос,*
- *Хөрс болон шаврыг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.*

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

## 2.2. ХӨРСНИЙ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

Шавар олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

## 2.3. УСНЫ ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

## 2.4. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдлоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

## 2.5. Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

## 2.6. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс

Тус тоосгоны шаврын ордын талбай нь байгалийн цогцолборт газарт хамаарахгүй бөгөөд түүх, соёлын дурсгалт зүйл талбайн хэмжээнд байхгүй. Хэрэв олборлолтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл дүүргийн болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандах хэрэгтэй.

## 2.7. ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮД

*Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа*

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх урсацын өөрчлөлт | | | X | | X | | | | | |
| Газрын доорх усны чанарын өөрчлөлт | | | | | | | | | | |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | X | | | | X | | X | | X | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | X | | | | X | | X | | X | |
| Геологийн тогтоцын өөрчлөлт | X | | | | X | | X | | X | |
| Зэрлэг амьтдын орон зай | | | | | | | | | | X |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | | | X | | | | | | | |
| 2. Байгалийн нөөц, ашиглалт | | | | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | X | | | | X | | | | | |
| Бэлчээрийн байдал | | | X | | X | | | | | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | X | | | | X | | | | | |
| Эрчим хүчний нөөц | X | | | | X | | | | | |
| 3. Байгаль, орчны өөрчлөлт | | | | | | | | | | |
| Ундны усны чанар, хэмжээ | | | | | | | | | | |
| Урсгал усны хэрэгцээ | | | | | | | | | | |
| Агаарын бохирдол | X | | | X | | | | | | X |
| Хөрсний эвдрэл, бохирдол | | | X | | X | | | | | X |
| Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх | | | X | | X | | | | | X |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | | | X | | X | | | | | |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | | X | | | | | | | X | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | | | X | | X | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | | | X | | X | | | | | |
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх | | | X | | X | | | | | |
| 5. Эдийн засаг, нийгмийн асуудал | | | | | | | | | | |
| Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх | X | | | | | | | | X | |
| Орон нутгийн орлого нэмэгдэх | X | | | | | | X | | | |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | X | | | | | | | | X | |
| Ажлын байр нэмэгдэх | X | | | | | | | | | X |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх | X | | | | | | | | X | |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | | X | | | | | | | | X |
| 6. Бусад нөлөөлөл | | | | | | | | | | |
| Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх | X | | | | X | | X | | X | |
| Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах | X | | | | | | X | | | X |
| Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих | X | | | | | X | | | | X |
| Хүчтэй салхи, уруйн үер | X | | | | | | X | | | |
| **Дүн** | **14** | **3** | **15** | **1** | **27** | **1** | **11** | | **6** | **11** |

# БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

## 3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харуулллаа.

*Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хугацаа, давтамж | Хэрэгжүүлэгч | Зардал, мян.төг | Гарсан үр дүн |
|---|---|---|---|---|---|
| **Хөрсөн бүрхэвч** | | | | | |
| 1 | Ажилчдад шатах, тослох материалтай хэрхэн харьцах, түүнээс үүсэх эрсдэлээс хэрхэн сэргийлж, ямар арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулсан | Жилд 1 удаа | “Күнлүн” ХХК | 100.0 | Шатах тослох материалын асгаралтаас сэргийлсэн |
| 2 | Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулсан | Төслийн үйл ажиллагааны явцад | “Күнлүн” ХХК | 300.0 | Хөрс элэгдэл эвдрэлд орох, тоосжилтоос сэргийлсэн |
| 3 | ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авч ажилласан. | Байнга | Байгаль орчны мэргэжилтэн | 200.0 | Хөрс бохирдохоос сэргийлсэн |
| 4 | Ажилчдын байрны ойр орчмыг цэцэрлэгжүүлсэн | Төслийн явцад | “Күнлүн” ХХК | 200.0 | Тоос босохоос сэргийлсэн |
| 5 | Хортон шавьжийн устгалыг тогтмол хийлгэж ажилласан. | Жилд 2 удаа | “Күнлүн” ХХК | 532.0 | Хөрс бохирдохоос сэргийлсэн |
| **Агаарын орчин** | | | | | |
| 1 | Шаврын олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн | Байнга | “Күнлүн” ХХК | Дотоод төлөвлөлтөөр | Тоосжилтоос сэргийлсэн |
| 2 | Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын сүү, цагаан идээ өгсөн | Байнга | “Күнлүн” ХХК | Дотоод төлөвлөлтөөр | Ажилчдын эрүүл мэндэд анхаарсан |
| 3 | Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авч ажилласан | Төслийн үйл ажиллагааны явцад | “Күнлүн” ХХК | 200.0 | Агаарын бохирдлоос сэргийлсэн |
| **Усан орчин** | | | | | |
| 1 | Үер усны аюулаас сэргийлэхийн тулд хамгаалалтын даланг нэмж байгуулсан, хуучин даланг сэргээн сайжруулсан | Төслийн үйл ажиллгааны явцад | “Күнлүн” ХХК | Дотоод төлөвлөлтөөр | Үер усны аюулаас сэргийлсэн |
| **Нийт дүн** | | | **1532.0** | | |

Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлж ажилчдын амрах, ая тухтай байх нөхцлийг сайжруулж ажиллав.




*Зураг 3.1. Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлсэн байдал*



Батлав "Нандин-Өргөө"-ХХК-ийн

Захирал ........ /Д.Пүрэвжав/

Батлав ........

/Аж ахуй нэгжийн нэр/

Захирал ........ /Овог нэр/

**Ахуйн шавьж мэрэг устгах, халдваргүйжүүлэлт хийх тухай гэрээ**

Нэг: Ерөнхий зүйл

Нэг талаас /үйлчлэгч/ халдварт өвчний тархан дэлгэрэх нөхцлийг таслан ахуйн шавьж,мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх "Нандин-Өргөө"ХХК-ийг төлөөлж тус компаний захирал Д.Пүрэвжав нөгөө талаас /үйлчлүүлэгч/ байгууллагад ........ ажилтай ........ нар тохиролцож 2023 оны 6-р сарын 10-ний өдрөөс эхлэн гэрээ байгуулав.

Хоёр: "Нандин-Өргөө" ХХК-иас хүлээх үүрэг

1. Үйлчлэгч тэл нь Эрүүл мэндийн тухай шинэчлэгдсэн хуулийн 41.1-р заалт болон МХЕГ-н даргын 2017-оны А/197-р тушаалаар батлагдсан /АХШМТэмцэх ариутгал халдваргүйтгэлийн байгууллагуудын ажиллах үлгэрчилсэн дүрэм/-н дагуу ахуйн мэрэгч шавьж устгах, урьдчилан сэргийлэх ажлыг технологийн дагуу 900 м2 ээлхүүн талбайд ариутгал устгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийнэ.
2. Ариутгал,устгал, халдваргүйжүүлэлтийг хийхийн тулд шавьж мэрэгчийн тархалтын түвшинг тогтоон, хорт бодисийн төрөл тун хэмжээг нарийвчлан тогтоож тэмдэглэнэ.
3. Илэрсэн шавьж мэрэгчийн хор хөнөөл болон урьдчилан сэргийлэх ариутгал халдвэргүйтгэл хийх талаар зөвөлгөө өгч үйлчилгээ хийх өдөр цагийг тогтоон ажлын хөлсийг дараах тарифийн дагуу гаргуулж авна.

| № | Үйлчилгээний нэр | Үнэ 1м2 талбайд | | |
|---|---|---|---|---|
| | | 1000м2 | 1000-2000м2 | 2000м2-с дээш |
| 1 | Ахуйн хортон шавьж/ялаа, бясаа, жоом,цагаан эрвээхий/ устгах | 600 төгрөг | 450 төгрөг | 400 төгрөг |
| 2 | Оготно,хулгана гэх мэт мэрэгч устгах | 600 төгрөг | 450 төгрөг | 400 төгрөг |
| 3 | Халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт | 350 төгрөг | 350 төгрөг | 250 төгрөг |

4. Үйлчилгээ хийх хор бодисыг MNS-1-2002 стандартын дагуу худалдан ав бэлтгэнэ.
5. Үйлччилгээний талаар тэмдэглэл бүртгэл хөтөлж үйлчилгээний үнэлгээ болон гарын үсгийг зуруулна.
6. Голомтот халдварт өвчин болон цар тахал гарсан үед халдваргүйтгэлийн ажлыг 14 хоногийн давтамжтай хийж гүйцэтгэнэ.
7. Үйлчилгээ хийгдэсний дараа 7, 14, 21 хоногт ажил үйлчилгээний үр дүнгийн талаар асуулт явуулах үзлэг шалтгалт хийх, баригч наалдуулагч тавьж шавьж мэрэгчийн тоог гаргах, үр дүнгийн талаар судалгааны хуудсанд тэмдэглэж цаашид авах арга хэмжээг төлөвлөнө.



Гурав: Үйлчлүүлэгч байгууллагаас хүлээх үүрэг

1. Үйлчлүүлэгч байгууллагаас Эрүүл мэндийн хуульд заасны дагуу ахуйн хортон шавьж мэрэг устгах болон урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэлийн ажлыг жилд 2-оос доошгүй удаа мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.
2. Халдварт өвчин дэлгэрсэн,ахуйн хортон шавьж мэрэгч тархсан, мэргэжлийн хяналтын байгууллагаас шаардлага тавьсан үед дуудлагаар үйлчлүүлнэ.
3. Ариутгал устгал халдваргүйжүүлэлт хийхийн өмнө тухайн орчинд цэвэрлэгээ хийж хогийг зайлуулан нүх цоорхойг бөглөж, цахилгаан хэрэгслийг түр салгаж, эд зүйлсийг хананаас зайдуу тавьж бэлтгэл хангана.
4. Дээрх шаардлагыг хангахгүйгээс үйлчилгээ хийлгэснээс хойш гарах асуудлыг бүрэн хариуцна.
5. Үйлчилгээний хөлсийг тарифийн дагуу төлнө.

Дөрөв: Төлбөр тооцоо

1. Төлбөрийг бэлнээр буюу нэхэмжлэхийн дагуу үйлчлэгч талд шилжүүлнэ.
2. Төлбөр тооцоог хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд хоног тутамд 0,5% алданги төлнө.

Тав: Хариуцлага

1. Гэрээлэгч талууд хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачлагаар энэхүү гэрээг цуцалж болно.
2. Бичиг баримтыг ашиглаж чанарын шаардлага хангаагүй бодисыг хувь хүнээс худалдан авсан тохиолдолд үүсэх хохиролыг үйлчлэгч тал хариуцахгүй.
3. Аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд учирсан хохиролыг Монгол улсын иргэний хуулийн дагуу шийднэ.
4. Гэрээг хоёр хувь үйлдэх ба эх хувиуд мөн адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үйлчлэгч байгууллагыг төлөөлж:

"Нандин-Өргөө " ХХК-ний ........

ажилтай ........ /Д.Пүрэвжав/

Утас: 99148255, 89158255

Гэрээг сунгасан: 99451289

Үйлчлүүлэгч байгууллагыг

төлөөлж ........

байгууллагын ........

ажилтай ........

| | |
|---|---|
| 2023 оны 6 сарын 10 өдрөөс | 2024 оны 6 сарын 10 өдөр хүртэл |
| 20....оны.... сарын.... өдрөөс | 20...оны....сарын.....өдөр хүртэл |
| 20....оны.... сарын.... өдрөөс | 20...оны....сарын.....өдөр хүртэл |
| 20....оны.... сарын.... өдрөөс | 20...оны....сарын.....өдөр хүртэл |
| 20....оны.... сарын.... өдрөөс | 20...оны....сарын.....өдөр хүртэл |

*Зураг 3.2. Ахуйн шавьш мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх гэрээ*



НАНДИН ӨРГӨӨ

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

20..оны 6 сар ..өдөр № 14. Налайх дүүрэг

Ахуйн Хортон Шавьж Мэрэгчийн

устгал хийсэн тухай акт

........ байгууллагын 360 м² талбайд

........ улсад үйлдвэрлэсэн ........

Бодисоор ахуйн хортон шавьж мэрэгчийн устгал ариутгал хийв.

Ариутгал, халдваргүйтэлд хэрэглэсэн химийн хорт бодисоос сэргийлэх санамж, анхааруулгыг өгч танилцуулав.

Үйлчлүүлэгчийн үнэлгээ:

Гарын үсэг:

Эрүүл ахуйн их эмч Д.Пүрэвжав



Сангийн сайдын 2017 оны
12 дугаар сарын 5-ны өдрийн
347 тоот тушаалын хавсралт

БЭЛЭН МӨНГӨНИЙ ОРЛОГЫН БАРИМТ

Дугаар 14 2023 он 6 сар 10 өдөр

Байгууллагын нэр Күнлүн ХХК

Мөнгө тушаагч ........ овогтой ........ -ээс

Гүйлгээний утга Шавьж устгалын үнэ

Тушаасан мөнгөний дүн 532000 төгрөг — мөнгө

Таван зуун гучин хоёр мянган төгрөг

Хавсаргасан баримт

Тэмдэг Дарга
Нягтлан бодогч
Хүлээн авсан
Мөнгө тушаагч

*Зураг 3.3. Шавьж устгалын төлбөрийн баримт*

## 3.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 2023 онд тусгай зөвшөөрлийн талбайн хойд төв хэсэгт 0.3 га газрыг түрж тэгшилсэн, биологийн нөхөн сэргээлтийн хүрээнд тоосгоны үйлдвэрийн талбайн хойд хил дагуу 0.15 га талбайд мод тарьж, хашаажуулж хамгаалсан.

Мөнх уурхайн талбайн баруун үргэлжлэлд залгаа орших эзэнгүй, өмнө нь эвдрэлд орсон талбайд 2021-2022 онд хийсэн нөхөн сэргээлтээ үргэлжлүүлж нийт 0.2 га талбайд нөхөн сэргээлт хийлээ. Мөн уурхайн талбайн дотор гарсан олон салаа замыг нэгтгэн түрж тэгшилж нөхөн сэргээлт хийлээ. Эдгээр ажлуудад нийтдээ 5.5 сая төгрөг зарцууллаа.




*Зураг 3.4. 2023 онд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай*




*Зураг 3.5. 2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай*



*Зураг 3.6. Нөхөн сэргээлт хийж буй байдал*



*Зураг 3.7. Уурхайн дотоод зам талбайг түрж тэгшилсэн байдал*




*Зураг 3.8. Нөхөн сэргээлт хийгдэж дууссан байдал*





*Зураг 3.9. Үйлдвэрийн талбайн дэргэд мод тарьж буй байдал*

## 3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2023 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд НБОГ-с санал болгосон Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр дэх Бага хуандийн аманд нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцохоор төлөвлөсөн.

*Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт*

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|---|
| - | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. | Дүйцүүлэн хамгаалалт | НБОГ-с санал болгосон газарт | Нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцоно | 1 | 2'500'000.0 | 2'500'000.0 |
| - | **Нийт** | - | - | - | - | **2'500'000.0** |

Энэхүү нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд 2.5 сая төгрөг шилжүүлэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлсэн.


ХААН БАНК
БАНК ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ / CLEARING
ОН/YYYY САР/MM ӨДӨР/DD
Гүйцэтгэх огноо / Value Date:
Хүлээн авагчийн/Recipient's Information
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 1102733850
Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:
Банкны нэр / Bank name:
Валют / Currency: MNT
Дүн Тоогоор / Amount: *2,500,000.00*
Дүн үсгээр / Amount in words: *Хоёр сая таван зуун мянган төгрөг*
Шилжүүлгийн утга / Description:
Шилжүүлгийн дараалал / Transaction queue:
Шилжүүлэгчийн / Sender's Information
Дансны № эсвэл IBAN / Account № or IBAN: 5027473539
Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:
Валют / Currency: MNT
Дүн Тоогоор / Amount: *2,500,000.00*
Дүн үсгээр / Amount in words: *Хоёр сая таван зуун мянган төгрөг*
Хүлээн авагчийн / Receiver's Information
